



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2011 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 691

Улаанбаатар хот

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 3.2, 3.3, 3.4 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн нийруулсугай:

“3.2. Түргэн борлогдох активыг касс дахь бэлэн мөнгө, Монголбанкинд байршуулсан хөрөнгө, бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, үнэт металл, Төв банкны болон Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны үнэт цаасны дүнгийн нийлбэрээс клирингийн дамжуулалтын saatlyн дансдын үлдэгдлийг хасч тооцно. Гэрээний үндсэн дээр хугацаа, хүүгийн хэмжээг тохироогүй, захиран зарцуулах эрх нь шилжин ирээгүй үнэт цаас, Монголбанкнаас банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон, татан буугдсан, дампуурсан, бүрэн эрхт төлөөлөгч, банкны эрх хүлээн авагч томилсон банкнаас авах авлага болон бусад банкинд үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгон барьцаалсан харилцах, хадгаламжийн үлдэгдлийг түргэн борлогдох активт оруулж тооцохгүй.”

“3.3. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцах, хадгаламж, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, бусад эх үүсвэр болон бусад өр төлбөрийн нийлбэр дүнгээс клирингийн дамжуулалтын saatlyн дансдын үлдэгдлийг хасч тооцно.”

“3.4 ТТГЧ-ын үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активыг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулж тооцох бөгөөд ТТГЧ-ын зохистой харьцааны доод хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.”

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 14 дүгээр хавсралтыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 213 дугаар тушаалын 2 дахь хэсгийн “... төгрөг, гадаад валютын хувьд..”, “...тус тус...” гэснийг хассугай.

4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны доод хэмжээг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 25 хувиар тогтоосугай.


5. Энэ тушаалыг мөрдөн ажиллахыг банкны Гүйцэтгэх захирал нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Б.Лхагвасүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Л.ПҮРЭВДОРЖ



14 1602



Хавсралт

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгuur үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам” ын 14 дүгээр хавсралт

БАНКНЫ ТӨЛБӨР ТУРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

... оны ... сарын ... өдөр

VХИ0014
(мянган төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
A	ТУРГЭН БОРЛОГДОХ АКТИВ /1+2+3+4+5-6-7/
1	Бэлэн мөнгө
2	Монголбанкинд байршуулсан хөрөнгө
3	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
4	Үнэт металл, Төв банкны үнэт цаас, ЗГ-ын үнэт цаас, репо үнэт цаасны нийлбэр дүн
5	Зг-ын баталгаатай Хөгжлийн банкны үнэт цаас
6	Банк хоорондын клирингийн тооцоны saatlyin данс
7	Тохируулга
B	БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГО /1+2+3+4+5-6-7/
1	Харилцах
2	Хадгаламж
3	Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр
4	Бусад эх үүсвэр
5	Бусад өр төлбөр
6	Банк хоорондын клирингийн тооцоны saatlyin данс
7	Тохируулга
V	ТӨЛ.ТҮР. ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (А/Б*100)
Г	ЗОХИСТОЙ ХАРЬЦАА
Д	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/
E	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ТУРГЭН БОРЛОГДОХ АКТИВ

Тайлбар: Хоёрдогч өглөгийг өр төлбөрийн дунд оруулан тооцохгүй

Банк хоорондоор харилцан байршуулсан аливаа харилцах, хадгаламж зээлийн дүнг цэвэрлэн тооцно

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/